

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо :**2016.08.04**

Тендер шалгаруулалтын нэр: **Увс аймгийн Завхан сумын сургуулийн барилгын засварын ажил гүйцэтгэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **УВБЗА-01/2016**

Увс Аймгийн Засаг Даргын Тамгын Газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Увс аймгийн Завхан сумын сургуулийн барилгын засварын ажил**–ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.meps.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ындагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000/ тавин мянга / төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь: Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ:**Сүүлийн 2 жил буюу 2014 2015 онуудад борлуулалтын орлогын дундаж нь 46.6 сая төгрөгөөс багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **65.3 сая төгрөгөөс багагүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2014-2015 он**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:**2014 2015 онуудад дор хаяж нэг удаа 46.6 сая төгрөгөөс багагүй**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тусгай зөвшөөрөл шаардлагатай**

Тендерийн хамт 932.000 **төгрөгийн** тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2016 оны 08 сарын 19-ний өдрийн 10 цаг 00 минут** –аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2016 оны 08 сарын 19-ний өдрийн 11 цаг 00 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Увс аймаг Улаангом сум 3-р баг
Ө.Бадрахын гудамж.Аймгийн ЗДТГ-ын
байр 1-р давхар 118 тоот**

Худалдан авах ажиллагааны алба

Утас 7045-32-62

www.e-procurement.mn, www.meps.gov.mn, www.uvstender.mn